

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№19/496

ШУС, НУС

2018

**РАДИО НЭВТРҮҮЛЭГТ ҮГ, ДҮРСЛЭХ ЯРИАГААР ЗУРАГЛАЛ БҮТЭЭХ НЬ**  
*(Сэтгүүлч Дан. Нямаагийн бүтээлийн жишээн дээр)*

Д.Батжаргал\*

\*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D)

**Түлхүүр үг:** радио сэтгүүл зүйн дүрслэх чадвар, сэтгүүлчийн онцлог, үгээр зураглал бүтээх нь, дүрслэх яриаг радиод тохируулан авах нь.

**Р**адио сэтгүүл зүйд “дүрслэн үзүүлэх” буюу нүдэнд харагдахуйц хэлж өгөх, микрофоноор зурна гэдэг өнөө цагийн залуу сэтгүүлчдэд үлэмж ховордсон чадвар. Бидний үед энэ эрдмийг нэн чухалчилдагсан. Наяад оны сүүлээр радиогийн чадварлаг сэтгүүлч Д.Пэлдэн “Микрофоноор зурах” гэдэг үгийг байнга хэлж ярьдаг байлаа. Монголын радио өвөрмөц нэвтрүүлэг, микрофоноор зурсан зураглал, жинхэнэ радио сурвалжлага гэх мэт богино хугацаатай уралдаанууд зарлан дор нь дүгнэдэг, өглөөний шуурхай дээр ямар хэлтсийн нэвтрүүлэг сонирхолтой сайн байсан, ямар нь уйтгартай, сонсогчдыг залхаасан, техникийн бичлэгийн түвшин муу байсан нь хэнийх вэ зэргийг шүүмжлэн хэлэлцдэгсэн. Энэ л үеэс радиогийн олон сэтгүүлч хөгжим, дуу чимээ, дүрслэх ярианаас гадна үгээр дүрслэл, зураг бүтээх нь хамгийн чухал юм байна, радиод ажиллаж байгаа сэтгүүлч энэ чадварыг эзэмших нь зайлшгүй юм байна гэдгийг ойлгосон юм. Тэдний нэг нь Данзангийн Нямаа.

Д.Нямаагийн нэгэн тэмдэглэлд монгол улсынхаа нэр сүр нь болж яваа найрагчдад ямар эрхэмсэг хүндлэл үзүүлдгийг зураглан харуулсан байна. Ийм зурвас зураглал түүний бүтээлүүдэд нэн олон. *“Охрид нуурын ус руу түрж орсон Дрим голын гүүрэн дээр тайз засчээ. Бүдүүн хулсыг шургааглан боож хооронд нь хэц татаад хоосон зайн дунд нь сонгодог монгол бичгээр бичсэн каллиграфуудыг дүүжилсэн нь тэнгэрийн дэлгэцэн дээр тодроод өвөрмөц харагдах бөгөөд тун ч модерн дүрсийг үүсгэх аж. Баруунтаа нь төрийн далбаагаа байрлуулав”* гэж “Эгшиглэнт Стругагийн тэмдэглэл”<sup>1</sup> - дээ хүндэтгэлтэй дагшин байдлыг эрхгүй гаргасан нь сонирхол татах аж. Тэгснээ огцом эргэлт хийнэ. Харь нутгийн тэнгэр доор эх орныхоо тухай санаашран буйгаа *“Эгэл жир ард нь ч шүлэг тууль хайлдаг бидний монголчууд ийм нэг олон улсын хэмжээний яруу найргийн наадамтай болвол тун ч сайн санаа. Одоо ч бид хандивлагчдын чуулганыг л жил бүр хийх юм шив дээ”* гэж бичээд *“Нутаг зүгрүү ниссэн нулимаст борхон бодлын шувуу эргэж ирэв. Машин тэрэг, хүн зоны хөдөлгөөн өтгөрчээ. Дрим голын шуугиан хотын чимээг дарна. Гүүрэн*

дээгүүр загасны иж бүрэн хэрэгсэл бэлдэж, уурга мөрлөсөн хөгшчүүд алхана. Ихэнх нь дуугуй хөтөлжээ... ” гэх мэтээр тэмдэглэлээ цааш өрнүүлсэн байх. Ерөөс эгшиглэнт халилууд нь сонсогчдыг улам барьж хүлээн авагчийн дэргэд “аргамжих” нь Нямаагийн бичлэгийн нэг өнгө аяс.

Тэрбээр хүнийг дүрслэхдээ тун дадмаг. Сэтгүүлч, яруу найрагч Чимиддоржийг үгээр бүтээсэн нь оновчтой тод сайхан зурагтай, хажууд суугаад ярьж байх шиг санагдана. 1980 оны долоон сард Нямаа, Чимиддорж хоёр радиогийн босгыг хамт алхжээ.

“Даргын өрөөний том, хуралдагсдын сүртэй, асуултын олныг хэлээд яах вэ? Одоо санахад, хамгийн гоё асуулт нь “Та хоёр хоёулаа, шүлэг бичдэг юм биз дээ?” гэсэн асуулт байж. Зэрэг шахуу л “Тийм” гэж хэлцгээсэн юмсан. Хамгийн чанга хариулсан хариулт л тэр байсан байх. Би дотроо “... энэ бас шүлэг бичдэг байх нь, нэг газар орж байна, танилцана даа ...” гэж бодож зогссон юмсан. Шалдан толгойтой, алтан саа болсон ахлагчийн погон бүхий цэрэг хувцастай, өтгөн хөмсөг, гал цахисан нүд, хянгандуу хамар, цэргээс халагдаад удаагүй гэхэд гялалзсан цайвар царай бүхий цог золбоотой эрсанж. Би болбоос бага зэрэг томдсон шинэ костюм дээр цагаан цамц өмсөж, түүн дэрээ дөрвөлжин хээтэй том зангиа унжуулж, баруун энгэр дээрээ “ромбо” зүүсэн

турхайнхай шар хүү байчухуй. Бид хоёр тэр өдрийн хуралдаанаар радиогийн сурвалжлагч болцгоосон юм. Ц.Чимиддорж “нэвтрүүлэгч” мэргэжлээр шалгалт өгөөд бас тэнцжээ. Дундговийн театрт дуучин ч байсан бололтой. Бас аймгийнхаа сонинд сэтгүүлч ч хийж явжээ. Элдэв асуултан дундаас иймэрхүү мэдээлэл олж сонсов. Авьяастай нөхөр юм. Хурлаас гарлаа. Хөлсөө арчицгаалаа. Танилцлаа<sup>2</sup>.

«

*Ерөөс эгшиглэнт халилууд нь сонсогчдыг улам барьж хүлээн авагчийн дэргэд “аргамжих” нь Нямаагийн бичлэгийн нэг өнгө аяс. Тэрбээр хүнийг дүрслэхдээ тун дадмаг. Сэтгүүлч, яруу найрагч Чимиддоржийг үгээр бүтээсэн нь оновчтой тод сайхан зурагтай, хажууд суугаад ярьж байх шиг санагдана*

»

Нэг нь үйлдвэрийн, нөгөө нь хүүхэд залуучуудын редакцид орохоор болсон хоёр нөхөр орох газрынхаа хаалгыг сэмхэн шагайчихаад дандаа эрэгтэй бичээчтэй юм гэж гайхсан гайхашрал, ажилд оруут нэвтрүүлгийн бичвэрээ шажигнатал машиндах болсон хийгээд “Монголын радиогийн сүүтэй босго тэр өдөр намсан байж, бидэн хоёрыг алхуулжээ” гэсэн дуу алдалт бүхэн сэтгэлийнх. Сэтгүүлч ажилдаа сэтгэлээ шингээх тусам тэр нь үгээр, дуу хоолойны нь өнгөөр илэрдэг жамтай.

Тэрбээр их сургуульд байхын уяхан, уянгалдаг Нямаа байлаа. Ерөөс эх төрөхийн уяхан хүн. Яруу найрагтаа, хүүрнэл зохиолдоо, аян замын тэмдэглэл, радио хөрөг найруулалдаа уянгална. Гайхалтай нь түүний уяхан сэтгэлийн гуниг, нулимс, инээд хөөр бүхэн бүтээл бүхэндээ үг болон шингээнэ. Заримдаа асгартал уйлж ч мэднэ. Түүний олон нэвтрүүлгийг тунгаан сонсвоос өндөр Баяраа

/зохиолч П.Баярсайхан/-гийн минь бусдад ихэмсэг, нөхдөдөө элгэмсэг дүр төрх, Чимиддоржийн адууны дэл шиг хар үгсээ хаялан “Төгөлдөр” гэж хэлэх дуун, сумын заан /яруу найрагч Ч.Мягмарсүрэн/-гийн маань “Захын унаа тахь, залгаж амжвал ахь, заларч орхивол хохь, замдаа зогсоолгүй бахь” хэмээн тайзан дээрээс дуудаж буй шүлэг, амьсгаа даран сонсох үзэгчдийн догдлол гээд олон олон зүйл нүднээ харагдаж дотнын найзтайгаа уулзсан мэт, сайхан хүмүүсийн энгүүн яриа өөрийн эрхгүй татна. Тэд бүгд радио сэтгүүлчид байлаа.

П.Баярсайханы тухай дурсамж нэвтрүүлэгтээ “Чиний ямар ч зохиол гайхалтай гүн санаа, далд зангилаа, сэтгэл зүйн санаанд багтамгүй эрэл туршилтууд, дүрийн дотоод чанадын гүн нарийн хувиралтууд, огцом өвөрмөц шийдэлтүүдтэй байдаг тэр л арга барил чинь дээрхи хоёр жүжигт гүнзгий тодоор илэрсэнсэн...” гэх мэтээр найрагчийн дотоод эргэцүүлэл бодлоор буурьтай судлаач мэт шигтгээ дүгнэлт хийсэн нь олонтаа.

Сэтгүүл зүй гэдэг тийм ч “зөөлөн боорцог” биш. Дандаа найз нөхөд хамт ажиллаж байсан нөхдийнхөө дүрийг бүтээхгүй. Өөрийнхөө зоргоор тэр бүрий хийгээд байх ч боломжгүй. Нэвтрүүлгийн бодлого, сонсогчдын хэрэгцээ шаардлага, олон нийтийн статус гээд олон зүйлийг бодох болно. Үүнийг бас чамгүй анзаарчээ. Эм найруулагч, цаг үйлдвэрлэгч гээд хахь ондоо мэргэжил үрүү хөрвөх нь зөндөө. Дан.Нямаа эдийн засагч мэргэжилтэй болохоор үйлдвэрийн редакцид ажиллаж олон нэвтрүүлгийг бүтээлцэж, заримыг нь санаачлан хийж явжээ. Энэ талаар Монголын радиогийн даргаар олон жил ажилласан, ахмад сэтгүүлч М.Чойжил “Үйлдвэрийн редакци

“Хуудас цаас”, “Шил савны тухай яриа”, “Чингэлэгтэй тээвэр”, “Холбоогүй холбоо”, “Хотын түүх, соёлын дурсгалт газрыг хамгаалья” зэрэг нэвтрүүлэг хийж, “Ажилч-дын нээлттэй микрофон” ажиллуулахад хариуцлагатай редактор М.Шийрэв, радиогийн тоотой эдийн засагчийн нэг Дан.Нямаа, сэтгүүлч С.Лхагвасүрэн, Дорж, Дамбадаржаа нарын олон уран бүтээлч авьяас зүтгэлээ зориулсан юм. Тэд “Бүх нийтийн чанарын үзлэг” нэвтрүүлэг явуулж улсын стандартын газартай хамтран жил бүр монголын радиогийн нэрэмжит арван шилдэг бүтээгдэхүүн шалгаруулж чанарын тэмдэг олгох ажил зохиож эхэллээ”<sup>3</sup> хэмээн тэмдэглэлийн номондоо бич-жээ. Ер нь нийтлэл нэвтрүүлгийг тойрон зохиох ажил үр өгөөжтэй байж тэр чинээгээр сэтгүүлчийн оролцоо их байсан юм.

**Н**ямаа ахуйн дүрслэлээс эхлээд амьдрал, хувь заяа орчлонгийн жам уруу үгээ ягуухан ивж өгнө. Цагаан хар, цагаан хар хосолсон төгөлдөр хуурын даруулгыг дүрсэлж байснаа “Амьдрал гэдэг ирэх буцах хоёр , учрах хагацах хоёр , баярлах, гуниглах хоёр бөгөөд яг л төгөлдөр хуурын даруулга мэт хар цагаан хослоно” гэх байдлаар утгын шилжилт хийнэ. Нэг үгээр хэлэх гэсэн санаагаа алгуур уусган дүрээ тодотгож гаргаж өнцгөө тууштай баримтлан бичдэг сэтгүүлч юм. “Монголоороо бахархах сэтгэл Сувдын хувьд үнэ цэнэтэй бөгөөд “хийж бүтээж, санаж сэдэж, зорьж тэмүүлж явах” –ын шидэт тарни нь болдог. Тэр хэзээ ч цээжээ хий хоосон балбагч байгаагүй юм. Түүний хувьд өдөр бүхэн шинэ. Шинэ өдөр бүхэнтэй хамтдаа ирдэг мөрөөдөл, хүсэл нь ч бас шинэ билээ...” гэх эрэгцүүлэл, “Амьдрал гэдэг ийм уярал мөрөөдөл тэгш, уяа чагтага

чанга, тасарч суларшгүй цаг хугацааны хэлхээс юм. Ийм л хэлхээс дунд Хадбаатар маань өөрийн зам мөрөө баттай гаргаж, улс орныхоо төлөө зүтгэж, түмэн олныхоо тусын тулд зүрх сэтгэлээ зориулж явна...” хэмээн ухаарал, бодрол элбэг. Түүний нэвтрүүлгүүдээс сонсогч таны хуучин танил Төрийн шагналт, зураач Б.Мөнхболд, “Их тайга” цайны эзэн Шагдарын Сувд, Монголын радиогийн нэвтрүүлэгч Жалсрайн Батаа, зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн Гангийн Жанчив, Ардын уран зохиолч П.Бадарч, Т.Галсан, Төрийн шагналт зохиолч П.Пүрэвсүрэн, “Паанан”, “Соёо” тууж, “Сүүлчийн хорчин” өгүүллэгээрээ олны анхаарал татсан зохиолч Доржзовдын Энхболд нарын хөргийг үгээр тодорхой дүрсэлжээ. Тэр хүмүүс Нямаагийн үгээр нүдэнд харагдаж, дуу хоолой, бүтээлээрээ зүрхэнд хоногшиж байна.

**Р**адио хэмээх хүчирхэг хэрэгсэл зон олны амьд яриаг бичиж соронзон хальснаа буулган авдаг болохоор бидний ярих дуртай “Ардын дүрслэлийн хэл” арвин байна. Ганцхан жишээ дурдахад ээжийнхээ тухай дурсамжид ахынхаа сайхан яриаг “Хожим нагац минь жаахан халангадуу үедээ “...оонын эвэр шиг хоёулханаа төрөөд таанын толгой шиг өсөж үржлээ...” гэж уйлсанаа дуулж, дуулсанаа уйлж суудагсан”<sup>4</sup> гэж оруулжээ. Манай ард түмэн гайхалтай билиг авьяастай нь ахынх нь ганцхан өгүүлбэрээс харагдана. Оонын эвэр, таанын толгой гэдэг нь дүрслэлээ тээж байгаа сайхан адилтгал юм.

Сэтгүүлч тэр бүр хүрч очих боломжгүй нөхцөлд очсон эх сурвалжийн яриаг дүрслүүлэх аргаар “Таныг очиход юу харагдаж байв, юу сонсогдож байв, юу үнэртэж байв” гэх

юм уу, “Танд ямар бодол төрж байв”, “Байр байдал төрхийг та зураглаад нүдэнд харагдахаар яривал ямар үг хэлэхсэн бол” гэх зэргээр аажуухан дөхөж очиж болно. Ерээд оны эхээр балар шигүү, атар онгон тайганд очсон хүний яриаг Монголын радиогоор нэвтрүүлж байсан, түүний хэсгээс хүргэе.

“Дээр үед бидний өвөг дээдэс ар давж булганы ан, наймаа хоёрт явдаг байсан тэр жимээр давж Тагнын таван давааны нэгээр давлаа. Тэнд ургасан хоёр хушны мөчир хоорондоо зөрөөд доогуураа харанхуйлчихсан, ерөөсөө нар харагдахгүй. Үнэн гоё орчлон тэнд байна аа...Бидний очсоны маргааш тэнд цас орсон. Есдүгээр сарын хорьдын орчим шүү дээ. Цас нь моддын орой мөчир шилмүүс дээр тогтчихсон. Газартаа хүрээгүй. Бүүдийсэн гэрэлтэй байшинд орчихсон юм шиг. Тэнд тогооны боролзгоно нов ногооноороо, шар цэцэг нь яг хэвээрээ, үгүй мөн гоё!!! Пээ, та нар явж үзсэн ч болоосой. Цааш явтал мэдрэл сүльдүүлсэн хачин үнэр. Жодоо модны үнэр үү, бүү мэд. Тэгснээ нэг их сайхан, бараг л “духи” гэмээр гайхамшигтай үнэр. Ёстой ч юу ч гэхэв дээ. Гэхдээ тэнд дуртай аавын хүү гозойтол давхиад очих газар яавч биш. Хад асга, хавцал уйтан, бартаа нуранги, бургас харгана ч ёстой нэг байна аа. Нууц товчоонд цатгалан могой шургаж чадахгүй балар шигүү ой гэж гардаг. Яг тийм балар тайгад очиж үзлээ. Ёстой ямар гэж санана. \дуу алдав\ Явж үзээгүй хүнд үгээр илэрхийлж болохгүй байна” гэх мэтчлэн ярьжээ. Тавагны амсар шиг том навч, хөрсөн дээр нь ямар ч шавьж үзэгдэхгүй хөлдөж байгаа тухай, хүн гээчийг үзээгүй гөрөөс буга согоо, үргэж айх жийрхэхээ мэдэхгүй

ангайтал хараад зогсож байсан зэргийг өгүүлэгч нүдэнд харагдтал дүрслэн ярьсан байна. *“Еэ би та нарт дүрслэн өгүүлж чадахгүй байна. Миний үгийн баялаг, илэрхийлэх чадвар ёстой нээ дутаж байна”*<sup>5</sup> хэмээн өгүүлсэн байна.

Монголын радио /хуучин нэрээр/-д 35 жил ажиллаж, сонсогчдын сайн танил болсон сэтгүүлч Дан.Нямаад ч энэ мэт яриа дүрслэл олон байна. Манай сэтгүүл зүйн түүхэнд хар толбо үлдээсэн “Гавьяанаас гайтсан сэтгүүлч”-ийн нэг Мөнхийн Шийрэвийн ярианд чихэр боовны үйлдвэрийн ажилчин хүү Содномжамцын тухай эх сурвалжаар дүрслүүлэн автобус хэрхэн шатсан, хүү ямар эр зориг гаргасан зэргийг тодорхой харуулжээ. Мөн Боловсролын их сургуулийн захирал, академич, шинжлэх ухааны доктор, профессор, гавьяат багш Бадрахын Жадамбаагийн ажил үйлс, зүтгэл тэмүүллийн тухай “Цээжний нөмөр” хөрөг дотор “Адис авмаар яасан олон ном бэ” хэмээн дуу алдаж байна. Энэ бол сэтгүүлчийн дотоод сэтгэлийн дуун алдалт, номд бишрэх Нямаагийн үг юм. Нөгөө талаар сонсогчийн чихэнд бас нэг сонин төсөөлөл бий болгож байна. Эцэст нь өгүүлэхэд, радиод үгээр дүрсэлдэг сэтгүүлчид олон бий. Дуу чимээгээр дүрслэл бүтээдэг ч найруулагч, уран бүтээлчид ч олон бий. Харин тэдний тухай судалгаа тун бага байна. Энэ талаар Монголын Үндэсний олон

нийтийн радио анхааралдаа авч “Алтан сан хөмрөг”-т байгаа бүтээлүүдээ хувилан судалгааны эргэлтэд оруулмаар санагдана. Тэгвэл радио сэтгүүлчдийн ур чадварыг дээшлүүлэхэд үр дүнтэй нөлөө, түлхэц болох биз ээ.

#### Ишлэл

- <sup>1</sup> Дан.Нямаа “Хүн гараг тэргүүт араажав цадигс” УБ, 2014, хуудас 198-207
- <sup>2</sup> Дан.Нямаа “Хүн гараг тэргүүт араажав цадигс” УБ, 2014 хуудас 176
- <sup>3</sup> М.Чойжил “Чихнээ сонсголт радио хэмээх тэмдэглэл” УБ, 2004, 153 дугаар тал
- <sup>4</sup> Дан.Нямаа “Хүн гараг тэргүүт араажав цадигс” УБ, 2014 хуудас 75
- <sup>5</sup> Д.Батжаргал “Дүрслэх ярианы гайхамшиг” МУИС, МХСС “Монгол судлал” ЭШБ 2013 №36 /386/

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Д.Батжаргал “Дүрслэх ярианы гайхамшиг” МУИС, МХСС “Монгол судлал” ЭШБ 2013 №36 /386/
2. Дан.Нямаа “Хүн гараг тэргүүт араажав цадигс” УБ, 2014
3. М.Чойжил “Чихнээ сонсголт радио хэмээх тэмдэглэл” УБ, 2004

#### Резюме

Автор статьи констатирует, что речь человека, шум и мелодия составляют основу радиопередач. Эти составляющие элементы создают образ и описание той или иной ситуации. В качестве примера автор анализирует некоторые произведения радиожурналиста Дан. Нямаа, который работал на монгольском национальном радио в течение 35 лет.